



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 6-р сарын 2 ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцуулах ажлыг зохицуулах, зохион байгуулах, суралцах хүмүүсийн талаар дүгнэлт гаргах комисс"-ын 2000 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. ✓ Юнгэрэнгийн Алтанхуягийг АНУ-ын Акронь Их сургуулийн магистрантурт 2 жилийн хугацаагаар, Бямбаагийн Сэлэнгийг АНУ-ын Радфордгийн Их сургуульд магистрантурт 1 жилийн хугацаагаар, ✓ Чунтын Эрхэмцэцэгийг Казахстан улсын Алма-Ата хотын Эрүүл Ахуй, Халдварт Өвчин Судлалын Эрдэм шинжилгээний Төвийн докторантурт 3 жилийн хугацаагаар тус тус 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.

2. АНУ-ын Колорадогийн Их сургуульд суралцаж буй Довдонгийн Дэмидийн суралцах хугацааг нэг семестрээр, АНУ-ын Мерсерийн Их сургуульд суралцаж буй Басхүүгийн Үлэмж, ХБНГУ-ын Бонн хотын Их сургуулийн магистрантурт суралцаж буй Гончигдоржийн Уянгахишиг, АНУ-ын Колорадогийн Их Сургуульд суралцаж буй Галбаатарын Сараа нарын суралцах хугацааг тус бүр нэг жилээр сунгасугай.

3. ОХУ-ын Москва хотын Эмч нарын Мэргэжил Дээшлүүлэх Институтын докторантурт суралцаж буй Дэнсмаагийн Бат-Очир, мөн хотын Тимирязевын нэрэмжит Хөдөө Аж Ахуйн Академийн аспирантурт суралцаж буй Цэдэвсүрэнгийн Алтанбат, Казахстан улсын Алма-Ата хотын Шинжлэх Ухааны Академийн докторантурт суралцаж буй Мухамадийн Хурметхан нарын хамгаалалтын зардлыг, Цагааны Төрбатын Франц улсын Париж хот дахь Цөмийн хүрээлэнд суралцсан хугацааны нэг сарын сургалтын төлбөрийг зээлээр олгосугай.



4. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан (Б.Ганбат)-д, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

САЙД



А.БАТТӨР



1998 оны 6 сар 9 өдөр.	Уг ий: № 215
... 7111- аймэг, хот сум,
дүүргийн нотариат би
энэ хуулбарын үнэмлэхүйг хурал.
Үйлчилгээний хэлсэлт хурал.
Нотариат